

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



“УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ” НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨВСГӨЛ АЙМГИЙН 15 СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ
464.8 ГА ГАЗАР НӨХӨН СЭРГЭЭГДЭЭГҮЙ ЭВДЭРЧ
ОРХИГДСОН БАЙНА.

АУДИТЫН КОД: : ГНАГ-2025/11-ШТА/-НА

Хөвсгөл аймаг
2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: teqshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 91890258 Цахим хаяг: davaadorjz@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: gurbazarn@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 86479090 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
<https://open.audit.mn/report>

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

З.Даваадорж

Аудитор

С.Гансүх

Н.Гүрбазар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2025 оны 06 дугаар сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

Бүлэг А. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглагч аж ахуйн нэгжүүд байгаль орчныг нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулж байна.

Бүлэг Б: Хөвсгөл аймгийн 15 сумын нутаг дэвсгэрт 464.8 га газар нөхөн сэргээгдээгүй эвдэрч орхигдсон байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Тайлангийн хавсралтууд

Холбогдох байгууллагуудын санал

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХӨТАГ	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/18

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/62 дугаар тушаал, 2023 оны А/102 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дахь заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө” нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөвсгөл аймгийн Байгаль орчны газар, сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Л.Төмөрбаатар), аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Базардамбуу), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базар, Байгаль орчны газрын дарга (Т.Лхагвадорж), Мөрөн сумын Засаг дарга Х.Тайванбаяр, Түнэл сумын Засаг дарга Ц.Чимэдмаа, сумдын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор (З.Даваадорж)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудиторын 2025 оны 6 дугаар сарын 17-ны
өдрийн А/18 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө”
нийцлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага

№	Албан шаардлагын дугаар	Утга	Дүн /сая.төг/
1	89/A2270438/ГНАГ-2025/11-ШТА-НА	Зөрчил арилгуулах тухай	-
2	90/A2270438/ГНАГ-2025/11-ШТА-НА	Зөрчил арилгуулах тухай	-
3	120/A2270437/ГНАГ-2025/11-ШТА-НА	Төлбөр барагдуулах тухай	279.8
4	121/A2270436/ГНАГ-2025/11-ШТА-НА	Төлбөр барагдуулах тухай	21.4
5	122/A2270436/ГНАГ-2025/11-ШТА-НА	Төлбөр барагдуулах тухай	1.6
Нийт дүн			302.8

оОо

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар дугаар тогтоол, МҮЕА-ын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 108 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

“Уул уурхайн нөхөн сэргээлтийн сангийн үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөө” сэдвийн хүрээнд судалгаа боловсруулж, дүн шинжилгээ хийн судалгааг Үндэсний аудитын газарт, дүн шинжилгээ хийсэн тайлан, дүгнэлт, зөвлөмжийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон холбогдох байгууллагуудад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Уул уурхайн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны орлого, зарлагын судалгаа боловсруулж, дүн шинжилгээ хийх,
- ❖ Уул уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалан нөхөн сэргээгдээгүй, эзэнгүй орхигдсон газрын судалгаа боловсруулж, дүн шинжилгээ хийх,

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хөвсгөл аймгийн уул уурхайн нөхөн сэргээх үйл ажиллагаанд холбогдох чиг үүрэг бүхий аймаг, сумдын ИТХ, Засаг дарга, Байгаль орчны газар, Газрын харилцаа, хот байгуулалтын газар, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэс, сумдын ЗДТГ, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, иргэн, холбогдох бусад байгууллагуудыг хамруулж 2020-2025 оны уул уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, тайланг, Уул уурхайн нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны орлого, зарлагын гүйлгээ, уул уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалан нөхөн сэргээгдээгүй, эзэнгүй орхигдсон газрын мэдээлэл, Бичил уурхай эрхлэгчдийн нөхөн сэргээлтийн дундын дансны орлого, зарлагын гүйлгээ, бусад холбогдох мэдээ, судалгаа, шийдвэрийг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

- Ашигт малтмалын тухай хууль
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль
- Газрын тухай хууль
- Газрын хэвлийн тухай хууль
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
- Байгаль орныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам /2014/
- Байгаль орныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам /2025/
- Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам
- Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг хүргүүлэх, ирүүлэх, хүлээн авах заавар
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журам

Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор З.Даваадорж, аудитор С.Гансүх, Н.Гүрбазар нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл:

Аудитын хугацаанд нөхөн сэргээгээгүй газрын буцааж нөхөн сэргээхэд шаардлагатай хөрөнгийг тооцох боломжгүй байна.. Учир нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын хамтарсан 2010 оны А-132/112 дугаар тушаалаар баталсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээ тооцох аргачлал” зааснаар нэгж талбар бүрд өөр өөр үнэлгээтэй нөхөн сэргээлтийн зардлын тооцоо гарахаас гадна нөхөн сэргээлтийн үнэлгээ тооцох мэргэжлийн байгууллага Хөвсгөл аймагт байхгүй байна.

Ерөнхий мэдээлэл:

Хөвсгөл аймагт 26 аж ахуйн нэгж 11,987.3 га талбайд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын 32 тусгай зөвшөөрөл эзэмшиж үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 27 ашиглалтын 5 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй байна.

Хуульд заасны дагуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүд нь аймгийн Засаг даргад уулын ажлын ажлын төлөвлөгөө, Орд ашиглах техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх нарийвчилсан үнэлгээ, дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт тухайн жилийн үйл ажиллагааны тайлан, маркшейдерийн хэмжилтээр тогтоогдож батлагдсан уулын ажлын үндсэн үзүүлэлт, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан зэрэг баримт материалыг хуулиар тогтоосон хугацаанд тухай бүр гарган ирүүлж байх үүрэгтэй байна.

Түгээмэл тархацтай /элс, хайрга, дайрга/ ашигт малтмал ашиглагч аж ахуй нэгжүүд нь байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагааны баталгаа болгож байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан тухайн жилд зарцуулах хөрөнгийн 50 буюу түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сумын Засаг даргын дэргэдэх баталгааны тусгай дансанд байршуулах үүрэгтэй байна. Харин түгээмэл тархацтайгаас бусад ашигт малтмалын тухайд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд байрших

баталгааны тусгай дансанд 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг байршуулах үүрэгтэй байна.

БҮЛЭГ А:

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАГЧ АЖ АХУЙН НЭГЖҮҮД БАЙГАЛЬ ОРЧНЫГ НӨХӨН СЭРГЭЭХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙНА.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 21 аж ахуйн нэгжээс 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулахгүй байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 5 аж ахуйн нэгж 1,416.7 га талбайд хайгуулын 5, 21 аж ахуйн нэгж 10,570.6 га талбайд ашиглалтын 27 тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 5 аж ахуй нэгж 2-3 тусгай зөвшөөрөл буюу 11 тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдийн 2 нь гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай ахуйн нэгж бол үлдсэн 24 нь дотоодын аж ахуйн нэгж байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт №1-ээс харна уу/

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №1

№	Сумын нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл, тоо	Ашигт малтмалын төрөл, тусгай зөвшөөрлийн тоо	Талбайн хэмжээ /га/
1	Алаг-Эрдэнэ	Ашиглалт-4	Чулуу (өнгөлгөөний) - 1 Хөнгөн цагаан - 2 Хайрга, дайрга-1	1,130.2
2	Арбулаг	Ашиглалт-1	Галт уулын шаарга-1	30.7
3	Бүрэнтогтох	Ашиглалт-9	Нүүрс - 2 Элс, хайрга, дайрга -3 Фосфорит - 4	1,734.2
		Хайгуул-3	-	93.1
4	Мөрөн	Ашиглалт-4	Элс, хайрга, дайрга - 2 Шохойн чулуу - 2	326.3
5	Түнэл	Ашиглалт-4	Фосфорит-1 Нүүрс - 1 Элс, хайрга дайрга -2	365.9
7	Цагааннуур	Ашиглалт-1	Өнгөт ба эрдэнийн чулуу-1	47.5
8	Цагаан-Уул	Ашиглалт-1	Молибден - 1	1,616.9
9	Цэцэрлэг	Ашиглалт-3	Нүүрс - 3	5,319.0
		Хайгуул-2	-	1,323.6
Нийт		Ашиглалт-27	Элс, хайрга, дайрга – 8 Нүүрс – 6 Фосфорит – 5 Хөнгөн цагаан -2 Шохойн чулуу – 2 Молибден - 1 Өнгөлгөөний чулуу -1 Галт уулын шаарга – 1 Өнгөт ба эрдэнийн чулуу-1	10,570.6
		Хайгуул-5	5	1,416.7

Хүснэгтэд үзүүлснээр Хөвсгөл аймагт байгаа ашиглалтын тусгай зөвшөөрлийн 30 хувийг элс, хайрга, дайргын, 22 хувийг нүүрс, 18 хувийг фосфорит, үлдсэн хувийг бусад ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд эзэлж байна.

Тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдээс хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 2 аж ахуй нэгж 2 нэгж талбарын 1,323.6 га талбайд, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 15 аж ахуйн нэгж 20 нэгж талбарын 10,194.3 га талбайд 2020 оноос 2025 онд ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт № 2-ээс харна уу/

Хөвсгөл аймгийн хэмжээнд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох дээд хэмжээг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны 6 дугаар сарын 26-ны 03 дугаар тогтоолоор тогтоосон байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №2

№	Байршил	Түгээмэл тархацтай ашигт малтмалын төрөл			
		Дайрга	Хайрга	Элс	Тоосгоны шавар, хүрмэн, боржин
1	Алаг-эрдэнэ сум	2	1	1	Илэрц бүхий сумдад тус бүр 1
2	Арбулаг сум	2	1	1	
3	Бүрэнтогтох сум	2	2	1	
4	Түнэл сум	2	2	2	
5	Мөрөн сум	1	1	2	
6	Төмөрбулаг сум	2	1	1	
7	Бусад сум бүрд 1	18	18	18	
	Нийт	29	26	26	24

Хүснэгтээс харахад Хөвсгөл аймагт нийт 105 түгээмэл тархацтай ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор тогтоосон байна. Үүнээс Мөрөн сум орчимд 5 байхаар тогтоосон нь Мөрөн суманд төрийн болон хувийн хэвшлийн бүтээн байгуулалт эрс нэмэгдсэн өнөөгийн нөхцөлд эрэлт хэрэгцээ, өрсөлдөөнийг хязгаарласан шинжтэй зохицуулалт болж байна. Иймд аймгийн Засаг даргад Мөрөн сумын түгээмэл тархацтай ашигт малтмалын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны үндсэн тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах санал оруулах зөвлөмж өглөө.

Тусгай зөвшөөрөлтэй зарим аж ахуй нэгжүүд шаардлагатай баримт, материалыг аймгийн Засаг даргад ирүүлээгүй байна.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд нь үйл ажиллагаа явуулах тухайн жил бүр уулын ажлын төлөвлөгөө гарган батлуулж, тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор аймаг, сумын Засаг даргад хүргүүлэх үүрэгтэй байна.

Аудитад хамруулсан 2020-2025 онд түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулсан 10 аж ахуйн нэгж 20 удаагийн уулын ажлын төлөвлөгөөг Хөвсгөл аймгийн Засаг даргад ирүүлж батлуулсан байна.

Харин хуульд заасан бусад баримт бичгийг бүрдүүлж ажилласан эсэхэд түүврийн хяналт хэрэгжүүлэхэд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй дараах аж ахуй нэгжүүд шаардлагатай баримт, материалыг аймгийн Засаг даргад ирүүлээгүй байна. Үүнд:

1. "Мөрөн бетон" ХХК :
 1. Орд ашиглах техник эдийн засгийн үндэслэл,
 2. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ,
 3. Дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт
 4. Тухайн жилийн үйл ажиллагааны тайлан,
 5. Маркшейдерийн хэмжилтээр тогтоогдож батлагдсан уулын ажлын үндсэн үзүүлэлт.
2. "Далай гоулд" ХХК:
 1. Дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт,
 2. Тухайн жилийн үйл ажиллагааны тайлан,
 3. Маркшейдерийн хэмжилтээр тогтоогдож батлагдсан уулын ажлын үндсэн үзүүлэлт.
3. "Эрдэм Үүд"ХХК:
 1. Орд ашиглах техник эдийн засгийн үндэслэл,
 2. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ,
 3. Дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт
 4. Маркшейдерийн хэмжилтээр тогтоогдож батлагдсан уулын ажлын үндсэн үзүүлэлт.

4. "Цагаагчууд констракшн" ХХК:

1. Орд ашиглах техник эдийн засгийн үндэслэл,
2. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ,
3. Дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт
4. Тухайн жилийн үйл ажиллагааны тайлан,
5. Маркшейдерийн хэмжилтээр тогтоогдож батлагдсан уулын ажлын үндсэн үзүүлэлт.

5. "Хөвсгөл зам" ХХК:

1. Дараа жилийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт,
2. Тухайн жилийн үйл ажиллагааны тайлан,
3. Маркшейдерийн хэмжилтээр тогтоогдож батлагдсан уулын ажлын үндсэн үзүүлэлт.

Дээр дурдсан баримт материалыг аймгийн Засаг даргад ирүүлээгүй байгаа нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5¹ дахь заалттай нийцэхгүй, дээрх компаниудыг хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа гэж үзэх үндэслэлгүй болгож байна. Аймгийн Засаг даргаас 2025 оны 05 дугаар сард түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглагч компаниудтай уулзалт дээрх зөрчлийг арилгах хугацаатай үүрэг, даалгаврыг өгсөн боловч аудитын хугацаанд зөрчил арилаагүй байна. Иймд дээрх зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Аймгийн Засаг даргад шаардлагатай баримт мэдээллийг ирүүлээгүй нь тухайн хуулийн этгээдийн олборлосон, үйлдвэрлэсэн, ачуулсан болон борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээг нарийвчлан тогтоох, олборлолтын хэмжээнд нийцүүлэн авах төлбөрийг тооцоолох нөхцөл боломжийг хязгаарласан үр дагаврыг үүсгэж байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдтэй аймгийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх "Хамтран ажиллах гэрээ"-г байгуулаагүй, "Эрдэм-Үүд" ХХК-тай 2024 онд гэрээ байгуулсан боловч гэрээний биелэлтийг тооцож ажиллаагүй байна. Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1²-т " гэж заасантай нийцэхгүй байгаа тул ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай "Хамтран ажиллах гэрээ" байгуулж, дүгнэж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй зарим аж ахуйн нэгжүүд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Ашигт малтмалын хайгуулын болон тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүд нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8³, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар баталсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 1.3⁴ дахь заалтад заасны тухай бүр гарган холбогдох Байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагаар батлуулж, хэрэгжилтийг хангах үүрэгтэй байна.

Аудитад хамруулсан 2020-2025 онд үйл ажиллагаа явуулж байгаа "Цагаагчууд констракшн" ХХК "Эрдэм-Үүд" ХХК, "Могойн гол" ХК, "Хөвсгөл зам" ХХК-ууд нь 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй зөрчил илэрч байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй аж ахуй нэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаа нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаа орхигдох эрсдэлийг үүсгэж байна. Иймд аймгийн БОАЖГ-т Байгаль орчны менежментийн

¹ Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээ, тайланг доор дурдсан хугацаанд аймаг, нийслэлийн Засаг даргад ирүүлнэ...:

² Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

³ Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална.

⁴ Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч боловсруулж, ерөнхий үнэлгээг хийсэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газарт хүргүүлэн хянуулж, батлуулна.

төлөвлөгөөг богино хугацаанд хийлгэж, баталгаажуулж ажиллах зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Ашигт малтмал ашиглагч аж ахуйн нэгжүүд 2020-2025 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө байгаль орчны техникийн нөхөн сэргээлтийг 57.0 га, биологийн нөхөн сэргээлтийг 54.7 га, дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг 40 га газарт хийхээр төлөвлөснөөс техникийн нөхөн сэргээлтийг 5.0 га, биологийн нөхөн сэргээлтийг хийгээгүй, дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг 17.5 га газарт хийсэн байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд Цэцэрлэг, Бүрэнтогтох, Цагаан-Уул сумдаас бусад сумд байгаль орныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс нээгээгүй байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүд нь үйл ажиллагаа явуулсан тухайн жилдээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9⁵-т заасны дагуу байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан тухайн жилд зарцуулах хөрөнгийн 50 буюу түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сумын Засаг даргын дэргэдэх баталгааны тусгай дансанд, ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүд нь хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10⁶-т заасны дагуу БОУАӨЯ-нд байрших тусгай дансанд тус тус байршуулах үүрэгтэй байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд Цэцэрлэг, Бүрэнтогтох, Цагаан-Уул сумдаас бусад сумд байгаль орныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай данс нээгээгүй байна.

Аж ахуй нэгжүүдийн 2020-2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заасан зардлын баталгааны мөнгөн хөрөнгийг тусгай дансанд байршуулсан байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 2 /мянган төгрөг/

№	Он	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Байршуулаагүй баталгаа хөрөнгө		Тайлбар
		Яаманд	Суманд	Яаманд	Суманд	Яаманд	Суманд	
1	2022	14,916.0	59,592.7	8,316.0	59,492.7	6,600.0	100.0	Яаманд төвлөрөх 6,500 мянган төгрөгийг Цэцэрлэг суманд андуурч төвлөрүүлсэн байна.
2	2023	11,936.2	362,272.5	11,936.2	-	-	362,272.5	Алаг-Эрдэнэ, Бүрэнтогтох сумдад баталгааны мөнгийг байршуулаагүй байна.
3	2024	24,029.5	23,064.5	24,029.5	-	-	23,064.5	
4	2025	11,649.5	411,243.0	-	-	11,649.5	411,243.0	Хүлээгдэж буй гүйцэтгэл
Нийт дүн		62,531.2	856,172.7	44,281.7	59,492.7	18,249.5	796,680.0	

Хүснэгтээс харахад БОУАӨЯ-нд төвлөрөх баталгаа мөнгөний гүйцэтгэл 71 хувьтай, сумдад төвлөрөх баталгаа мөнгөний гүйцэтгэл 7 хувьтай сумдад 796,680.0 мянган төгрөгийн баталгаа мөнгө төвлөрөөгүй хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна. Тухайлбал Бүрэнтогтох суманд хайрга олборлож ашиглаж байгаа “Далай гоулд” ХХК 2024 онд 21,445.0 мянган төгрөг, “Эрдэм үүд” ХХК 2024 онд 1,619.5 мянган төгрөг, “Бээжин юни констракшн

⁵ Энэ хуулийн 9.10-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

⁶ Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ.

групп Монголиа” ХХК 2025 онд 279,798.0 мянган төгрөгийг байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны тусгай дансанд байршуулаагүй байна.

Аудитаар байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны тусгай дансанд мөнгөн хөрөнгийг байршуулаагүй зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

Хөвсгөл аймгийн сумдад байгаль орчныг нөхөн сэргээх баталгааны мөнгийг байршуулаагүй байгаа нь түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглагч аж ахуй нэгж болон сумдын Засаг дарга нар Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ Б:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН 15 СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ 464.8 ГА ГАЗАР НӨХӨН СЭРГЭЭГДЭЭГҮЙ, ЭВДЭРЧ ОРХИГДСОН БАЙНА.

Хөвсгөл аймагт аж ахуй нэгжүүдийн уул уурхай, бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас шалтгаалан эвдэрч, нөхөн сэргээгдээгүй 351.7 га талбай байна.

Ашигт малтмал ашиглагч ашиглагч аж ахуй нэгжүүд нь олборлолт хийсэн газартаа хууль, журамд заасны дагуу эхлээд газрыг байгалийн зөв тогтоцтой /налуулга, дүүргэлт, тэгшилгээ/ болгох техникийн нөхөн сэргээлтийг хийсний дараа нь ургамалжуулах биологийн нөхөн сэргээлтийг хийх 2 үе шаттай арга хэмжээг авч нөхөн сэргээлт хийх үүрэгтэй байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 13 аж ахуй нэгж 8 сумын нутаг дэвсгэр дэх 110 байршил, 351.7 га талбайд нөхөн сэргээлт хийгээгүй байна. /Нөхөн сэргээлт хийгээгүй газруудын жагсаалтыг хавсралт №3-аас харна уу/ Үүнээс 56 байршил 102.8 га талбайд эхний үе шатны техникийн нөхөн сэргээлт хийсэн боловч биологийн нөхөн сэргээлтийг хийгээгүй бусад 54 байршлын 248.9 га талбайд нөхөн сэргээлт огт хийгээгүй байна. Уул уурхай, автозамын ажлын үйл ажиллагаанаас нөхөн сэргээгүй газрын мэдээллийг сумд тус бүрээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 3

№	Сум, дүүрэг	Нэгж талбарын тоо	Нөхөн сэргээгдээгүй талбайн хэмжээ /га/	Нөхөн сэргээлт хийсэн байдал
1	Алаг-Эрдэнэ	36	79.3	65.6 га-д техникийн нөхөн сэргээлт хийсэн, биологийн нөхөн сэргээлт хийгээгүй
2	Бүрэнтогтох	10	39.2	3.7 га-д техникийн нөхөн сэргээлт хийсэн, биологийн нөхөн сэргээлт хийгээгүй
3	Их-Уул сум	13	18.4	5.8 га-д техникийн нөхөн сэргээлт хийсэн, биологийн нөхөн сэргээлт хийгээгүй
4	Тариалан	13	37.5	Нөхөн сэргээлт огт хийгдээгүй
5	Тосонцэнгэл	23	48.1	Нөхөн сэргээлт огт хийгдээгүй
6	Түнэл	12	27.7	27.7 га-д техникийн нөхөн сэргээлт хийсэн, биологийн нөхөн сэргээлт хийгээгүй
8	Цагаан-Уул	1	13.7	Нөхөн сэргээлт огт хийгдээгүй
9	Цэцэрлэг	2	87.9	15.0 га-д дүйцүүлэх нөхөн сэргээлт хийсэн
Нийт дүн		110	351.7	

Уул уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалан эвдэрч орхигдсон газрууд



Жилчиг булаг: “Мон-Ажнай” ХХК /Нүүрсний уурхай/



Нүүрстэйн ам /443-р хорих анги ашиглаж байсан/

Автозамын ажилд хайрга, дайрга ашигласнаас эвдэрч орхигдсон газрууд



Тосонцэнгэл сум



Их-Уул сум



Тариалан сум



Хатгал тосгон Ардгийн сайр /Хатгал-Жанхайн чиглэлийн авто зам барих

Аудитаар эвдэрч орхигдсон газруудын судалгааг хийж дараах аж ахуй нэгжүүд нөхөн сэргээлт хийгээгүй байна. Үүнд:

1. Булган - Мөрөн - Хатгал- Жанхай чиглэлийн автозамыг тавьсан "Арж капитал" ХХК, "Гашууны гол" ХХК, "Бээжин Юни-Констракшн групп" ХХК, "Пик девелопмент" ХХК, "Их Монгол барилга" ХХК, "Хотгор зам" ХХК, "Эйч Ки Би" ХХК нь зам дагуух Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл, Түнэл, Бүрэнтогтох, Алаг-Эрдэнэ сумдын 103 нэгж талбараас түгээмэл тархацтай ашигт малтмалыг тусгай зөвшөөрөлгүй олборлон зам тавихад ашиглаж 214.6 га газрыг бүрэн нөхөн сэргээлгүй /107.3 га-д техникийн нөхөн сэргээлт хийсэн/ орхисон байна.
2. Хөвсгөл АЗЗА ХХК нь Бүрэнтогтох сумын Их-уул баг Эрүү цахир, Угсуургын сайрын ар болон Цэцэрлэг сумын 4-р баг Нарийн ухаа, Улаан толгой гэх газарт 4.4 га газарт түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон боловч нөхөн сэргээлт хийлгүй орхисон байна.
3. Чулуун нүүрс олборлож байсан Нүүрстэйн ам, Жилчиг булгийн нүүрсний уурхайн 31.4 га газарт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, "Мон-Ажнай" ХХК нар нь нөхөн сэргээлт хийлгүй орхисон байна.
4. Цагаан-Уул сум Өвгөд баг /2-р баг/-ийн газар нутагт Молибден, вольфрамын хайгуул гүйцэтгэж байсан "Монгол ресурс корпораци" ХХК нь 13.7 га газарт нөхөн сэргээлт хийлгүй орхисон байна.

Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1⁷ болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1⁸ дахь заалтуудтай нийцэхгүй хуулиар хүлээсэн чиг үүргээ аж ахуй нэгжүүд хэрэгжүүлээгүй байгааг харуулж байна.

⁷ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 38, 39 дүгээр зүйлд заасан үүргийг биелүүлнэ.

⁸ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон энэ хуулийн 27, 28 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлнэ.

Мөнх Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3⁹ болон Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3¹⁰ заасны дагуу ашигт малтмал ашиглагч аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж гарсан зөрчлийг арилгуулах шууд чиг үүрэг аймаг, сумдын Засаг дарга нарт байгаа боловч дээрх чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй нь байгаль орчин нөхөн сэргээгдээгүй үлдэх шалтгаан нөхцөл болсон байна. Иймд дээрх зөрчилд холбогдох байгууллагуудаар нөхөн сэргээлтийг хийлгэх эсхүл хохирлыг нөхөн төлүүлэх талаар арга хэмжээ зохион байгуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Хөвсгөл аймагт хариуцах эзэн тодорхойгүй эвдэрч орхигдсон 113.1 га газар байна.

Хөвсгөл аймгийн 10 суманд эзэн холбогдогчийг тогтоох боломжгүй 113.1 га талбай эвдэрч орхигдсон байдалтай байна. Эзэнгүй орхигдсон газарт тодорхой хэмжээний нөхөн сэргээлт хийсэн мэдээллийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №3

№	Сум	Эзэнгүй орхигдсон газрын хэмжээ /га/	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ авсан талбайн хэмжээ /га/	Санхүүжилтийн эх үүсвэр	Зарцуулсан дүн /мян.төг/
1	Алаг-Эрдэнэ	1.1	-	-	-
2	Баянзүрх	2.6	-	-	-
3	Бүрэнтогтох	29.9	4.4	орон нутгийн төсөв	21,348.0
4	Жаргалант	2.0	-	-	-
5	Мөрөн сум	15.0	-	-	-
6	Рэнчинлхүмбэ	0.4	-	-	-
7	Улаан-Уул	48.0	-	УТУТХГ, БОАЖГ	6,000.0
8	Цэцэрлэг	0.3	-	-	-
9	Чандмань-Өндөр	9.7	9.4	-	-
10	Эрдэнэбулган	4.0	-	-	-
Нийт дүн		113.1	13.8		27,348.0

Хүснэгтэд үзүүлсэн нийт эзэнгүй орхигдсон газрын 12.2% буюу 13.8 га талбайд орон нутгийн болон бусад холбогдох байгууллага техникийн нөхөн сэргээлт хийсэн бол Улаан-Уул суманд 48.0 га талбайд орчны цэвэрлэгээ хийсэн байна.

